

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ХХААХҮЯмны сайдын 2023 оны А/18 дугаар тушаалын дагуу Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь Мал аж ахуйн алба, Захиргаа аж ахуйн алба, Үйлдвэр, худалдаа үйлчилгээний алба, Хяналтын алба гэсэн 4 алба нийт 20 орон тоотойгоор орон нутагт ХХААСалбарын бодлого шийдвэр, хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХХААГ-ын мэргэжилтэй боловсон хүчний хүрэлцээ хангамж 100 хувь хангагдсан. Төрийн албаны ангиллын хувьд Төрийн захиргааны албан хаагч-13, төрийн үйлчилгээний албан хаагч-7, төрлөөр удирдах-1 гүйцэтгэх-12 туслах-7 албан хаагч ажиллаж байна. Төрийн захиргааны албан хаагчид тавигдах ерөнхий болон тусгай шаардлагын хангасан албан хаагчид ажиллаж байна. 2023 онд 1 албан хаагч төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцэн томилогдсон. Мэргэжилтэй боловсон хүчин 100 хувь хангагдсан. Сул орон тоо байхгүй.


Төрийн захиргааны 13, төрийн үйлчилгээний 7 албан хаагчтайгаас 11 буюу 55 хувь нь эрэгтэй, 9 буюу 45 хувь нь эмэгтэй албан хаагч эзэлж байгааг доорх графикаар харуулж байна.



Боловсролын хувьд дээд боловсролтой албан хаагч 15 буюу 75 хувийг, тусгай дунд болон бүрэн дунд боловсролтой албан хаагч 25 хувийг эзэлж байна.


Боловсролын байдал

- Дээд боловсролтой албан хаагч
- Тусгай дунд болон бүрэн дунд боловсролтой албан хаагч




Байгууллагын албан хаагчдыг насны ангиллаар авч үзвэл 35 хүртэл насны залуучууд 3 буюу 15 хувь 35 дээш насны албан хаагчид 13 буюу 65 хувийг 45 дээш насны 4 албан хаагч 20 хувийг ажиллаж байна .

Насны ангилалаар



Төрийн албанд ажилласан жилээр авч үзэхэд 0-5 хүртэл жил 5, 6-10 жил 6, 11-15 жил 4, 16-20 жил-2, 21-26 жил 2 буюу нийт албан хаагчдын 73,6 хувь нь 6 дээш жил тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид байна.


Ажилласан жилээр



Нийт албан хаагчдаас 9 албан хаагч буюу 45 хувь нь орон сууцанд, 8 албан хаагч буюу 42 хувь нь гэрт, 1 албан хаагч түрээсийн байранд, 2 албан хаагч нийтийн сууцанд амьдарч байна.



Ажилтнуудын 30 хувь нь буюу 6 албан хаагч 750,000-912,000 төгрөгний , 10 албан хаагч буюу 50 хувь нь 1,100,000-1,320,000 төгрөгний цалинтай, 4 албан хаагч 20 хувь нь 1,452,000-1,757,000 төгрөгний үндсэн цалинтай ба албан хаагчдын 89,4 хувь нь орон сууцны болон хэрэглээний цалингийн зээлтэй байна.




ХҮНС, ХӨДӨӨ АЖ АУЙН ГАЗРЫН БҮТЭЦ ОРОН ТОО



СУМДЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ ТАЛААР

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/209 тоот тушаалаар сумдын хөдөө аж ахуйн тасгийн орон тоо, албан хаагчдын хариуцах чиг үүргийг батлан ЗДТГ-ын бүтэц орон тоонд ажиллаж байна.




Сумдын хөдөө аж ахуйн тасагт дутагдалтай орон тоо

Д/д	Сумын нэр	Нийт орон тоо	Ажиллаж байгаа	Дутагдалтай
1	Адаацаг	3	1	2
2	Баянжаргалан	3	1	2
3	Говь-Угтаал	3	1	2
4	Гурвансайхан	3	1	2
5	Дэлгэрхангай	3	2	1
6	Дэлгэрцогт	3	1	2
7	Дэрэн	3	1	2
8	Луус	3	1	2
9	Сайнцагаан	3	2	1
10	Хулд	3	1	2
11	Цагаандэлгэр	3	1	2
12	Эрдэнэдалай	3	3	
13	Өлзийт	3	1	2
14	Сайхан-Овоо	3	0	3
15	Өндөршил	3	1	2
	Бүгд	45	18	27


ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН СУДАЛГАА СУМДААР

2023 оны 10 сарын байдлаар



ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН ОРОН ТООГ ГРАФИКААР ХАРУУЛАХАД


2023 оны 10 сарын байдлаар



Сумдын Хөдөө аж ахуйн тасагт нийт 45 албан хаагч ажиллахаас 18 албан хаагч тогтвор сууршилтай ажиллаж байна. 27 албан хаагч дутагдалтай. Сумын Хөдөө аж ахуйн тасгийн боловсон хүчний хангалт 60 хувьтай.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГТ АЖИЛЛАЖ БУЙ АЛБАН ХААГЧДЫГ ХАРИУЦАХ ЧИГ ҮҮРГИЙН БАЙДЛААР

хөдөө аж ахуйн тасгийн албан тушаалтнуудыг хариуцах чиг үүргийн байдлаар



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР